

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН
НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, ОЛОН
НИЙТЭД МЭДЭЭЛЭХ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/12-ШТА-НА

Чойбалсан хот 2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4-5
1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 7 нам, 1 эвсэл, 758 нэр дэвшигчээс 5 нам, 506 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг төрийн аудитад мэдэгдэж, бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй байна.....	6
1.1 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 5 нам сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг аудитад мэдэгдэж, бүртгүүлээгүй байна.....	6-7
1.2 1.2 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 506 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг аудитад мэдэгдэж, бүртгүүлээгүй байна.....	7-9
2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.....	10
2.1 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцож зардлын тайлангаа ирүүлсэн нам, эвсэл нь ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.....	10
2.2 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцож зардлын тайлангаа ирүүлсэн нэр дэвшигчид ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.....	10
ДҮГНЭЛТ:.....	10
ЗӨВЛӨМЖ.....	11-12
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	13
ХАВСРАЛТ.....	14-17

Товчилсон үгийн тайлбар

НА	Нийцлийн аудит
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ШТА	Шууд тайлагнах аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МАН	Монгол ардын нам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл <p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нам, эвсэл нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг тайланг хянаж баталгаажуулсан.</p>
Аудитын зорилт	Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын ажлыг гүйцэтгэхэд Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүй, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны А/07 дугаартай “Дорнод аймгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай” тушаалыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, аудитор М.Ганбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн. Аудитын талбарын ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлүүлж, тайланг ҮАГ-ын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлж, иргэд, олон нийтэд Төрийн аудитын байгууллагын цахим хуудсаар мэдээлж ажиллаа.

Үндсэн мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 24 тойрогт аймагт 7 нам, 1 эвслийн 92 нэр дэвшигч, 1 бие даагч, 14 сумын 10 тойрогт 4 нам, 1 эвслээс 642 нэр дэвшигч, 30 бие даагч нэр дэвшсэн байна.

Хүснэгт 1

д/д	Нам, эвсэл бие даагчийн нэрс	нам	Аймагт нэр дэвшигч	Суманд нэр дэвшигч
1	Ардчилсан нам	1	35	279
2	Монгол ардын нам	1	35	283
3	Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам	1	1	-
4	Иргэний Зориг Ногоон Нам	1	3	16
5	Иргэний Хөдөлгөөний Нам	1	4	29
6	Үндэсний эвсэл	1	8	35
7	Үнэн ба Зөв Нам	1	1	-
8	ХҮН Нам	1	5	-
9	Бие даагч		1	30
	дүн	8	93	672

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 765 нэр дэвшигчээс 7 нэр дэвшигч нь аймаг, суманд зэрэг нэр дэвшсэн байна. Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд нийт 758 иргэн нэр дэвшсэн байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 2 нам, 1 эвслийн дансанд нийт 57,605.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 52,581.0 мянган төгрөг зарцуулж, харилцах дансанд 5,024.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 204 нэр дэвшигчдийн дансанд нийт 619,639.9 мянган төгрөгийн мөнгөн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 619,221.4 мянган төгрөг зарцуулж, харилцах дансанд 418.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 7 нам, 1 эвсэл, 758 нэр дэвшигчээс 5 нам, 506 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг төрийн аудитад мэдэгдэж, бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй байна.

1.1 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 5 нам сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг аудитад мэдэгдэж, бүртгүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн 2 нам, 1 эвсэл, бүртгүүлээгүй 5 нам байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан хугацаандаа ирүүлсэн 2 нам, 1 эвсэл тайлангаа ирүүлээгүй 5 нам байна.

Нам, эвслийн сонгуулийн зардлын санхүүжилтийн 57,605.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг орлогын ангиллаар харуулбал. Үүнд:

Хүснэгт 2

Үүнээс: Орлогын ангилал					
№	Нам, эвсэл нэр	Нийт орлогын дүн	Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	Иргэний өгсөн нийт мөнгөн хандив	Хуулийн этгээдийн өгсөн нийт мөнгөн хандив
1	Ардчилсан нам	9,000.0	-	4,000.0	5,000.0
2	Монгол ардын нам	48,605.0	30.0	48,575.0	-
3	Үндэсний эвсэл	-	-	-	-
дүн		57,605.0	30.0	52,575.0	5,000.0

Хүснэгтээс харахад нам, эвсэлд 48 иргэн 52,575.0 мянган төгрөгийн, хуулийн этгээд 5,000.0 мянган төгрөгийн, нам, эвслээс 30.0 мянган төгрөгийн нийт 57,605.0 мянган төгрөгийн хандив өгсөн байна.

Нам, эвсэл сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 52,581.0 мянган төгрөг зарцуулснаас сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардалд 32,710.0 мянган төгрөг, нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардалд 19,199.0 мянган төгрөг, бусад зардалд 672.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт 3

Үүнээс: Зардлын ангилал							
Д/д	Нам, эвсэл	Нийт зардлын дүн	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах, хөлс, урамшууллын зардал	Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	Сонгуулийн сурталчилгаанд ашиглах бусад зардал	Бусад зардал
1	Ардчилсан нам	3,400.5	-	3,399.7	-	0.6	0.2
2	Монгол ардын нам	49,180.5	32,710.0	10,950.0	2,250.0	2,598.7	671.8
3	Үндэсний эвсэл	-	-	-	-	-	-
	дүн	52,581.0	32,710.0	14,349.7	2,250.0	2,599.3	672.0

Мөн Цагаан-Овоо сумын МАН 24.0 мянган төгрөг, аймгийн Ардчилсан нам 5,024.0 мянган төгрөг нийт 5,024.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс ирүүлсэн зардлын тайланг хянаж үзэхэд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив аваагүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу 2 нам, 1 эвслийн зардлын дансны хуулгыг ХААН банк, Төрийн банк ирүүлсэн байна.

1.2 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 506 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг аудитад мэдэгдэж, бүртгүүлээгүй байна.

Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн 252 нэр дэвшигч, бүртгүүлээгүй 506 нэр дэвшигч байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 198, хугацаа хоцроосон 6, тайлангаа ирүүлээгүй 554 нэр дэвшигч байна. Нийт 204 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулж ирүүлсэн байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 630,439.9 мянган төгрөгийн 619,639.9 мянган төгрөг нь мөнгөн, 10,800.0 мянган төгрөг нь мөнгөн бус хандив байна. Үүнд:

Хүснэгт 4

Орлогын төрөл	Орлого /мянган төгрөг/				Нийт	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	2	5,000.0	0	-	2	5,000.0
Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	54	197,492.8	0	-	54	197,492.8
Хуулийн этгээдийн хандив	19	119,449.0	1	6,000.0	20	125,449.0
Иргэний хандив	577	297,698.1	16	4,800.0	593	302,498.1
ДҮН	652	619,639.9	17	10,800.0	669	630,439.9

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 619,221.4 мянган төгрөг зарцуулжээ. Үүнд:

Хүснэгт 5

Зардлын ангилал		Мөнгөн дүн /мянган төгрөг/
д/д	Сонгуулийн зардлын дүн	619,221.4
1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах зардал	122,490.2
2	Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах, хөлс, урамшууллын зардал	364,263.5
3	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардал	5,169.8
4	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	5,141.2
5	Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	31,526.3
6	Ухуулах байрны түрээсийн зардал	20,940.5
7	Бусад цахим хуудсыг сурталчилгаанд ашиглах нам, эвсэл болон нэр дэвшигчийн зардал	9,030.6
8	Бусад зардал	41,308.3
9	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	3,624.0
10	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийлүүлэх зардал	6,864.3
11	Сонгуулийн сурталчилгаанд ашиглах бусад зардал	8,435.9
12	Нам, эвслээс зарцуулах томилолтын зардал	426.9

Нэр дэвшигчдийн зардлын тайланд нийт 418.5 мянган дансны үлдэгдэлтэй байна.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон гүйлгээний утга буруу, иргэний бүртгэлийн дугааргүй 163 иргэн, хуулийн этгээдийн 45,623.2 мянган төгрөгийн хуулиар зөвшөөрөөгүй хандивыг буцаасан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг Дорнод аймаг дахь арилжааны 5 банк ирүүлсэн байна.

2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэг нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

2.1 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцож зардлын тайлангаа ирүүлсэн 2 нам, 1 эвсэл нь ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 7 нам, 1 эвслээс сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан хугацаандаа ирүүлсэн 2 нам, 1 эвслийн зардлын тайланг хянаж үзэхэд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

2.2 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцож зардлын тайлангаа ирүүлсэн 204 нэр дэвшигч ТАБ-аас тогтоосон зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 764 нэр дэвшигчээс сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан хугацаандаа ирүүлсэн 204 нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж үзэхэд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан зардлын дээд хэмжээг баримтлан ажилласан байна.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 7 нам, 1 эвсэл, 758 нэр дэвшигчээс 5 нам, 506 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг төрийн аудитад мэдэгдэж, бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй байна.

2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчээс 48 нэр дэвшигч зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын байгууллагад ирүүлэх үүргээ биелүүлээгүй байна.

Аудитаар аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг төрийн аудитын байгууллагад мэдэгдэж, бүртгүүлээгүй 5 нам, 506 нэр дэвшигч, сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй 48 нэр дэвшигч илэрсэн тул хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагад 2 зөвлөмж өгч ажиллаа.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

1. Дорнод аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст

Сонгуулийн зардлын тайлан ирүүлээгүй нэр дэвшигч нарт Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дүгээр зүйлийн 25. “Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар 6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийн шалган шийдвэрлэнэ” гэж заасны дагуу уг хуулийн 6.22 “**Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч** Зөрчлийн тухай хуулийн ..., **17.1 дүгээр зүйлийн 25**, 27 дахь хэсэгт заасан зөрчил”-ийг шалган шийдвэрлэнэ. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 170 дугаар тогтоолоор баталсан “Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм”-ийн 2.4-т “Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт улсын байцаагчийн эрх олгоно” гэж заасан байна.

Зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй 48 нэр дэвшигч нарт хуульд заасан арга хэмжээг авах.

2. Дорнод аймгийн Татварын газарт

Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг төрийн аудитын байгууллагад мэдэгдэж, бүртгүүлээгүй нам, нэр дэвшигч нарт Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21. Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийн шалган шийдвэрлэнэ” гэж заасны дагуу уг хуулийн 6.12 “**Татварын улсын байцаагч** Зөрчлийн тухай хуулийн ..., 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил”-ийг шалган шийдвэрлэнэ.

Сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг төрийн аудитын байгууллагад мэдэгдэж, бүртгүүлээгүй 5 нам, 506 нэр дэвшигч нарт хуульд заасан арга хэмжээг авах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “*Шалгаагдагч этгээд*”

болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. гэсэн заалтын дагуу төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн дотор ирүүлнэ.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/29

Чойбалсан хот

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболдод хүргүүлсүгэй.

3. Аудитаар зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд, аудитын тайланг Төрийн аудитын байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд мэдээлж ажиллахыг мэдээлэл, технологи хариуцсан аудитор М.Ухаанбилэг нарт тус тус даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010216

Хавсралт 1

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэлд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

д/д	Хандив авсан намын нэр	Хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийн нэрс	Хандивын хэмжээ /мянган. төгрөг/
1	Булган сумын МАН	Т.Гантулга	2,000.0
2	Баянтүмэн сумын МАН	П.Гунгаацэрэн	2,000.0
3	Баянтүмэн сумын МАН	Э.Жавхлантөгс	2,000.0
4	Баянтүмэн сумын МАН	Н.Болдбаатар	2,000.0
5	Цагаан-Овоо сумын АН	П.Мөнх-Эрдэнэ	1,000.0
6	Цагаан-Овоо сумын АН	У.Даш	1,000.0
7	Дорнод аймгийн МАН	Болормаа	2,000.0
8	Дорнод аймгийн МАН	Батцэцэг	2,000.0
9	Дорнод аймгийн МАН	Нарансоёл	2,000.0
10	Дорнод аймгийн МАН	Сайн-Учрал	2,000.0
11	Дорнод аймгийн МАН	Дорждэрэм	2,000.0
12	Дорнод аймгийн МАН	Ганболор	2,000.0
13	Дорнод аймгийн МАН	Эрдэнэзул	2,000.0
14	Дорнод аймгийн МАН	Тэмүүжин	2,000.0
15	Дорнод аймгийн МАН	Нандин-Эрдэнэ	2,000.0
16	Дорнод аймгийн МАН	Оюунчимэг	2,000.0
17	Дорнод аймгийн МАН	Энхжаргал	2,000.0
18	Дорнод аймгийн МАН	Адилбиш	2,000.0
19	Дорнод аймгийн МАН	Түвшинтөгс	2,000.0
20	Дорнод аймгийн МАН	Болормаа	2,000.0
21	Дорнод аймгийн МАН	Энхдалай	1,000.0
22	Дорнод аймгийн МАН	Насандэлгэр	2,000.0
23	Дорнод аймгийн МАН	Даш-Эрдэнэ	2,000.0
24	Дорнод аймгийн МАН	Л.Түвдэнням	2,000.0
25	Дорнод аймгийн МАН	Тунгалагсайхан	1,285.0
26	Дорнод аймгийн Ардчилсан нам	Сүбүтэй майнинг сервис ХХК	5,000.0
			51,285.0

Хавсралт 2

Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

д/д	Нэр дэвшигч	Иргэн, хуулийн этгээдийн нэрс	Хандивын хэмжээ /мянган. төгрөг/
1	У.Уртнасан	Д.Галтогтох	2,000.0
2	Г.Цолмон	Хөх Монгол принтинг ХХК	6,000.0
3	Г.Цолмон	Н.Оюунчимэг	1,000.0
4	Э.Мөнхтөр	Ц.Лхамдулам	2,000.0
5	Э.Мөнхтөр	Н.Оюунтуяа	2,000.0
6	С.Галт	Талын Таван Өндөр Трейд ХХК	10,000.0
7	А.Амарцэнгэл	Э.Чулуунгэрэл	2,000.0
8	А.Амарцэнгэл	А.Батмөрөн	2,000.0
9	Б.Эрдэнэбулган	Насантуяа	2,000.0
10	Э.Анхбаяр	Гео тана сүрвэй ХХК	2,000.0
11	Ж.Мөнгөнтуул	Н.Ганболд	2,000.0
12	Г.Ууганбаяр	Э.Түвшинбат	1,000.0
13	Г.Ууганбаяр	П.Мөнхөө	1,000.0
14	Г.Ууганбаяр	П.Туяа	2,000.0
15	Г.Ууганбаяр	Г.Нандинцэцэг	1,000.0
16	Г.Ууганбаяр	С.Алтанчимэг	1,800.0
17	Г.Ууганбаяр	Ч.Пүрэвсүрэн	2,000.0
18	Г.Ууганбаяр	П.Эрдэнэзул	1,800.0
19	А.Гантулга	Х.Ундрах	1,000.0
20	Ү.Бөхчулуун	Ариунтунгалаг	2,000.0
21	Ү.Бөхчулуун	Ч.Амгалантөгс	2,000.0
22	Г.Оюунтуяа	Х.Ариунгэрэл	1,000.0
23	Г.Оюунтуяа	Г.Нарангэрэл	2,000.0
24	Г.Оюунтуяа	Ж.Отгонцэцэг	2,000.0
25	Г.Оюунтуяа	Н.Энх-Амар	2,000.0
26	П.Болормаа	Б.Отгонбаяр	2,000.0
27	П.Болормаа	Эрдэнэцэцэг	1,000.0
28	Н.Батмөнх	Б.Сүлдбаяр	1,000.0
29	Н.Батмөнх	Б.Анхбаяр	2,000.0
30	Н.Батмөнх	Н.Отгонбаатар	1,000.0
31	Д.Тамиржаргал	О.Эрдэнэтуяа	1,080.0
32	Д.Мөнхбат	Ш.Чулуун	1,000.0
33	Т.Гантулга	Энхтөгс	2,000.0
34	Т.Гантулга	Д.Базаргүр	2,000.0
35	Б.Цог	Сувд шилтгээн ХХК	10,000.0
36	С.Ганбат	Ж.Довдонбалжир	2,000.0
37	Ш.Дэлгэрсайхан	Ган хэрлэн ХХК	3,000.0
38	Г.Золбаяр	С.Цэнгүүн	2,000.0
39	П.Мөнхбат	Х.Ундрах	1,000.0
40	П.Мөнхбат	О.Отгонзул	1,000.0
41	Б.Бат-Эрдэнэ	М.Сугарсүрэн	1,000.0
42	Б.Бат-Эрдэнэ	Мянган айл ХХК	5,000.00

43	Б.Бат-Эрдэнэ	Б.Батхуяг	1,000.00
44	Б.Бат-Эрдэнэ	Б.Айдын	1,700.00
45	Б.Орхончимэг	Б.Батболд	1,000.00
46	Б.Бат-Эрдэнэ	Д.Гантулга	2,000.00
47	Б.Бат-Эрдэнэ	Б.Базаргүр	1,000.00
48	Б.Бат-Эрдэнэ	Хаанхүнс ХХК	10,000.00
49	Б.Төгсжаргал	Д.Батмөнх	2,000.00
50	Ө.Ганбат	Л.Анхмаа	1,000.00
51	Э.Нарангарав	Ц.Цогзолмаа	1,000.00
52	Ж.Ёндонжамц	Сноуфилдс ХХК	5,000.00
53	Х.Энхбаатар	Э.Балжмаа	1,000.00
54	Б.Гансэлэм	Саруултөгс	1,000.00
55	Т.Бат-Эрдэнэ	Н.Оюунбаатар	1,000.00
56	Ч.Баттулга	Э.Болорцэцэг	2,000.00
57	Ч.Баттулга	А.Мөнхтуяа	1,000.00
58	Ч.Баттулга	Ж.Даваажаргал	1,000.00
59	Ч.Баттулга	Б.Пүрэв	1,000.00
60	Ч.Баттулга	Д.Батбилэг	1,000.00
61	Ш.Ёл	Ж.Түвшинжаргал	1,000.00
62	Ш.Ёл	М.Отгонбаяр	1,000.00
63	Ш.Ёл	Г.Мөнхжаргал	1,800.00
64	Ш.Ёл	Баярсайхан	2,000.00
65	Ш.Ёл	Ш.Саранчимэг	2,000.00
66	Ш.Ёл	Ц.Батгэрэл	2,000.00
67	Ш.Ёл	Т.Төмөрбаатар	1,000.00
68	Ш.Ёл	М.Майнбаяр	2,000.00
69	Ш.Ёл	Дорнын өглөг	10,000.00
70	Э.Эрдэнэчулуун	Б.Түмэннаст	2,000.00
71	Э.Эрдэнэчулуун	Мөнхбуян	2,000.00
72	Э.Эрдэнэчулуун	Б.Ганбат	1,000.00
73	Э.Эрдэнэчулуун	Г.Болор-Эрдэнэ	2,000.00
74	Э.Эрдэнэчулуун	Г.Цэнгэлбаяр	2,000.00
75	Э.Эрдэнэчулуун	Идэрмөнх	2,000.00
76	Б.Мөнх-Од	Б.Жамбалсанжид	1,000.00
77	Б.Одбаяр	Оргилуун өргөө ХХК	5,000.00
78	Э.Түвшин	Чандмань тал ХХК	9,850.00
79	М.Энхтөр	Дорно модерн тауэр ХХК	10,000.00
80	Ц.Сүхбаатар	М.Бадамгарав	2,000.00
81	Ц.Сүхбаатар	Н.Энхцогт	2,000.00
82	Ц.Сүхбаатар	Б.Пүрэвбат	2,000.00
83	Ц.Сүхбаатар	Э.Энхсайхан	1,700.00
84	У.Энхчимэг	Э.Бямбажав	2,000.00
85	Н.Гэрэлцэцэг	Алтан талын хийморь ХХК	10,000.00
86	Л.Наранхүү	Лхүндэв	1,000.00
87	Л.Наранхүү	Наранбаяр	1,000.00
88	Л.Наранхүү	Л.Отгонболд	2,000.00
89	Л.Наранхүү	Э.Нарантунгалаг	2,000.00
90	Л.Наранхүү	М.Мөнхбаатар	1,000.00
91	Б.Сэргэлэнбаатар	Бямбаханд	2,000.00
92	Б.Сэргэлэнбаатар	Даш	2,000.00
93	Б.Сэргэлэнбаатар	Мядагмаа	2,000.00
94	Б.Сэргэлэнбаатар	Ө.Болормаа	2,000.00
95	Б.Сэргэлэнбаатар	Цэдэнханд	2,000.00

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх аудит

96	Б.Сэргэлэнбаатар	Батжаргал	2,000.00
97	Б.Сэргэлэнбаатар	Нансалмаа	2,000.00
98	Ч.Гэрлээ	Ц.Цолмонгэрэл	2,000.00
99	Ч.Гэрлээ	Д.Батзориг	2,000.00
100	Ч.Гэрлээ	Болорцэцэг	2,000.00
101	Ч.Гэрлээ	Г.Гэрэлмаа	1,000.00
102	Б.Болортөгс	Т.Жавхлан	2,000.00
103	Г.Наранчулуун	Т.Жавхлан	2,000.00
104	Г.Наранчулуун	М.Мөнхбаяр	2,000.00
105	Г.Наранчулуун	Д.Мөнхцэцэг	1,000.00
106	Г.Наранчулуун	Г.Наранбаатар	1,120.00
107	Э.Батхолбоо	Д.Сувдаа	2,000.00
108	Э.Батхолбоо	Х.Тунгалаг	1,000.00
109	Э.Батхолбоо	Э.Баттулга	2,000.00
110	Х.Хүрэл-Эрдэнэ	Б.Чингүүн	2,000.00
111	Э.Жавхлан	Б.Анхцэцэг	2,000.00
112	Э.Жавхлан	Ц.Сэрээжид	2,000.00
113	Э.Жавхлан	Т.Цэцэгмаа	2,000.00
114	Э.Жавхлан	Т.Оюунгэрэл	2,000.00
115	Д.Өлзийбаяр	Д.Доржсайхан	2,000.00
116	Д.Өлзийбаяр	Д.Батнасан	2,000.00
117	Д.Өлзийбаяр	Хишиг агро ХХК	9,900.00
118	Ч.Ганбат	Б.Энхболор	1,500.00
119	Ч.Ганбат	Бодисмаа	1,900.00
120	Ч.Ганбат	Гантуяа	2,000.00
121	Ч.Ганбат	Алдармаа	2,000.00
122	Ч.Ганбат	Г.Төрбат	2,000.00
123	Ч.Ганбат	Чанагдорж	2,000.00
124	Ч.Ганбат	Алтангэрэл	2,000.00
125	Ч.Ганбат	Батцэцэг	2,000.00
126	Ч.Ганбат	Өнөрбулган	2,000.00
127	Ч.Ганбат	Ч.Анхдаваа	2,000.00
128	Б.Батбаатар	Б.Батцэцэг	2,000.00
129	С.Мөнхжаргал	Дэрин	2,000.00
130	С.Мөнхжаргал	Уранчимэг	1,000.00
131	С.Мөнхжаргал	С.Баатар	2,000.00
132	С.Мөнхжаргал	М.Халиун	2,000.00
133	С.Мөнхжаргал	М.Отгонтөгс	2,000.00
134	С.Мөнхжаргал	М.Батзориг	2,000.00
135	Н.Жалхаа	О.Энхтуул	1,000.00
136	Н.Жалхаа	О.Чалхааням	1,900.00
137	Д.Ганбаяр	Нарма тээвэр ложистикс ХХК	3,000.00
138	Б.Отгонбаатар	Сувд Салоны ажилчид	2,000.00
139	Б.Отгонбаатар	86002660	2,000.00
140	Б.Отгонбаатар	Л.Пүрэвдорж	2,000.00
141	Б.Отгонбаатар	Д.Ганчулуун	2,000.00
142	Б.Эрдэнэчимэг	Нарма тээвэр ложистикс ХХК	10,000.00
143	Э.Баатарсүх	Миг даатгал ХХК	3,000.00
144	Г.Эрдэнэзул	Ц.Бат-Эрдэнэ	2,000.00
145	Э.Батболд	Ц.Түмэнтуяа	2,000.00
146	Э.Батболд	Э.Оюунболд	1,500.00
147	О.Билгүүн	Нарма ХХК	3,000.00
			340,550.0

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN